

Монголын гэр бүлийн бүтэцийн зарим тоон үзүүлэлт

О. Сүхбаатар

Хүн Судлалын Үндэсний Төвийн

Эрдэм Шинжилгээний Ажилтан

Монголчууд 15-р зууны эхэн үеэс эхлэн, эхлээд Монгол, Ойрд дараа нь Ар, Өвөр, Ойрд, Буриад, Хөх нуурын Монгол гэж хуваагдан өөр хоорондоо гол төлөв гадаадын түлхээс, хоорондын эрх мэдлийн төлөө тэмцэл гэсэн хоёр голлох шалтгаанаар тэмцэлдэж, үндэстний нэгдсэн хүн амын төрийн бодлогогүй болсон тэр үеэс эхлэн хүн ам нь аажмаар цөөрч ирсэн билээ. Үүний уршгаар гэр бүл өрхийн уламжлалт бодлого ч алдагдаж эхэлсэн юм. Гадаадын довтолгоон, өөр хоорондын дайн тулааны улмаас үхэл хагацал, өнчрөл, бэлэвсрэл айл гэр бүрийг ямар нэг хэмжээгээр хамарч, хүн амын нас хүйсний тэнцвэр байнга доголдож байлаа.

Монголд шарын шашин дэлгэрснээс монголчуудын гэр бүлийн хэвийн бүтэц байнгын доголдолтой болсон төдийгүй нийгмийн хэвийн зүй тогтол байх ёстой мэт сэтгэгдэх болжээ. Хүн амын ялангуяа эмэгтэйчүүдийн эрүүл мэнд доройтож, төрөлт дэлхийд хамгийн бага болж, эх нялхсын эндэгдлээр дэлхийд хамгийн их үзүүлэлттэй болсон байв.

Хятад орон Манжийн ноёрхлын үед хүн амаа 3 дахин өсгөсөн бол Монголын хүн ам 2 дахин хорогдсон байлаа. Энэ зууны эх гэхэд насанд хүрсэн эрэгтэйчүүдийн 1/3 нь лам болж шавилан сууж, гэр бүлгүй амьдарч, гурваас дээш хүүхэдтэй айл аль ч нутаг хошуунд нэн ховордож, айлууд гол төлөв 1-2 хүүхэдтэй байлаа. Төрөх үеийн эхийн эндэгдэл их, эмэгтэйчүүдийн наслалт богино болсон төдийгүй төрсөн хүүхдүүдийн 50 хувь нь 3 нас хүрэлгүй нас бардаг байв. Эрэгтэйчүүдийн үлэмж хэсэг нь гэр бүлгүй лам нар байснаас гэр бүлгүй эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин бусад улс орныхоос их, бэлгийн замын халдварт өвчин дэндүү их тархсан, үргүйдэл хүн амын ихээхэн хэсгийг хамарсан байсан юм. Манж-Хятадын алсын хорон санаат бодлогын уршгаар 1918 онд манай орны нутагт дөнгөж 542,5 мянган Монголчууд оршин сууж байсан нь өнөөгийн нийслэл Улаанбаатарын хүн амаас 20 шахам хувиар цөөн, тодруулбал одоогийн баруун 6 аймгийн хүн амтай тэнцэх хэмжээний байсан билээ. Чухам ийм учраас гадаадынхан Монгол бол сөнөж буй үндэстэн гэж бичдэг болсон үе байв. Манж хятадууд Монгол орныг олон жижиг хошуудад хувааж засаг захиргааны хувьд түгжигдмэл байдалд барьж байх, хүн амын үндэсний нэгдсэн бодлогогүй болгож аажмаар тоог нь цөөрүүлэн хөнөөх бодлогыг маш алгуур мэт боловч шаргуу чимээгүй явуулж байсны уршгаар Монголын хүн амын гэр бүл, өрхийн бүх үзүүлэлт дэлхий нийтийн жишээгээс дэндүү гажуудсан байв. 1920-иод оны Монголд олон хүүхэдтэй айл цөөн, элэг бүтэн айл бараг байсангүй нь нийгмийн жирийн үзэгдэл болсон, өрөөсгөл өрхийн тоо бүтэн өрхийн тооноос давсан нэн гажуу тогтолцоотой орон байв.

1921 онд гадаадын түрэмгийлэгчдийг хөөн гаргасны дараа өрх, гэр бүлийн бүтцэд зохистой өөрчлөлт гарч эхэлсэн боловч, "зүүнтний" үед тайж нарыг ангийн хувьд шахан устгах, лам нарыг цэргийн алба болон татвараас чөлөөлөх алдаатай бодлого явуулсны улмаас тайж нарын өрхөд бэлэвсэрсэн эх хүүхдүүдийн хувийн жин нэмэгдэж, лам нарын тоо 80-120 мянга хүрснээс гэр бүлгүй хүмүүс, нөхөргүй эмэгтэйчүүдийн тоо хурдан өсөв. 1922-1940 оны хооронд амь үрэгдсэн эрчүүдийн 15 мянга шахам өрх, хагас өрх болж хувирчээ. 1935-1947 онд цэргийн албанд жилд дунджаар 80 мянга хүртэл эрчүүдийг барьж байснаас гэрлэлт багасч, цэргийн ар гэр 20-30 мянган өрх бий болжээ. 1946-1947 он хүртэл гэрлэх насанд хүрсэн эмэгтэйчүүдийн 30-40 хувь нь гэр бүлгүй амьдарч байсан нь хүн амын өсөлтөнд муугаар нөлөөлсөн юм. Ер нь 1950-иад он хүртэл хүн амын тоо өсөхгүй шахам байсан нь хүн амд гэр бүлтэй хүмүүсийн хувийн жин байнга бага байсантай шууд холбоотой байв. Энэ нь нийгэм эдийн засгийн хөгжил, хүн амын аж амьдралын түвшинд ч муугаар нөлөөлж байсан юм. Энэ үед төрөлт, хүн амын өсөлт бага, хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн хувийн жин бага, нялхасын болон эхийн эндэгдэл их,

хүүхдийн дунд бутач болон хагас өнчин хүүхдийн хувийн жин нэлээд өндөр байв. Бэлгийн замын халдварт өвчин тархмал байснаас хүн амын өвчлөлт их, төрөлт бага хэвээр байв.

1950-иад оноос Ж.Самбуу нар Монгол улс 15-р зуунаас хойш хүн амын бодлого байхгүй байсан алдааг олж хараад, Монгол төрийн хүн амын нэгдсэн бодлого явуулах болсон нь хүн амыг эрүүлжүүлэх, эрүүлийг хамгаалах ажлыг төрийн бодлогын хэмжээнд ухаалаг аядуу шаргуу явуулж эхэлснээр илэрлээ олж, богино хугацаанд үр дүнд хүрсэн юм. ЗХУ-аас арьс өнгө, улаан бурхан, сүрьеэ зэрэг нийгмийн онц халдварт өвчнөөс сэргийлэх, эмчлэх ангиудыг урьж ирүүлэн, хүн амаа эрүүлжүүлж эхэлсний дүнд төрөлт, хүн амын өсөлт нэмэгдэж, өвчлөлт нас баралт эрс буурав. Гэр бүлийг бэхжүүлэх, гэр бүлгүй хүмүүсийн хувийн жинг бууруулах, хүн амын төрөлт өсөлтийг нэмэгдүүлэх ажлыг нийгэм эдийн засгийн төлөвлөлт арга хэмжээгээр дамжуулан буурь суурьтай, алдаа багатай тасралтгүй шаргуу явуулав. 1960-аад оны дунд үе гэхэд гэр бүлгүй хүмүүсийн хувийн жин багасаж, хүн амын нас хүйсний харьцаа тогтворжин нийт хүн ам ялангуяа эхчүүд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд эрс сайжирч, эмч нарын тоо бүтэц бүрэлдэхүүн, мэргэжлийн ур чадвар тухайн үе ийнхээ шаардлагын хэмжээнд үндсэндээ хүрч, хүн амын тоо Монголын 500 жилийн түүхэнд анх удаа 1 саяас давж, эрүүл мэндийн олон үзүүлэлтээр дэлхийн жишигт хүрчээ.

Хүн амын өсөлтийг улс орны нийгэм эдийн засагт даралт үзүүлэхүйц хэмжээнд хүргэлгүй өөрөөр хэлбэл 1000 хүнд оногдох төрөлтийг 50-аас дээш, жил тутмын хүн амын ердийн цэвэр өсөлтийг 3,5 хувиас хэтрүүлэхгүй байж чадсан нь хүн амын бодлогыг туйлын сайн тооцоолол, үндэслэлтэй явуулж байсныг гэрчилнэ. Хүн ам эрүүлжиж, гэр бүлийн байдал тогтворжсоны шууд нөлөөгөөр хүн амын хөдөлмөр эрхлэлт сайжирч, улс ардын аж ахуйн олон салбарыг ээлж дараалалтай хөгжүүлэх нөхцөл бүрэлдэв. 1970-аад оны эхнээс энэ байдал улам бэхжиж, 1950-иад онд төрсөн залуучууд, хөдөлмөрийн нөөцийн эгнээнд шилжиж, хүн амын гэр бүлийн бэхжилт улам сайжирч, хүн амын нас хүйсний бүтэц нэн зохистой байдалд хүрэв. Энэхүү зохистой байдал улам тогтворжин хэвшиж, 1980-аад оны дунд үе хүртэл үргэлжлэв. Харин 1980-аад оны сүүлчээс хүн амын цэгцэрсэн бодлогоос гуйвж дайвж эхэлсний уршгаар, хүн амын хөгжилд жигдрэн тогтворжиж байсан зарим үзүүлэлт гажуудалд орж эхлэв.

Монгол улсын өрхийн тоо, хэмжээ, үндсэн тогтолцоонд дүн шинжилгээ хийхгүйгээр хүн ам судлалын голлох шинжийг тодорхойлох боломжгүй юм. Хүснэгт 1 ээс дүгнэлт хийхэд нэг өрхөд дунджаар 4,7 хүн буюу эхнэр, нөхөр хоёулаа, 2 хүүхэд, хоёр талынхаа аль нэг хөгшинтэй хамт аж төрдөг дэлхийн түгээмэл дундаж үзүүлэлттэй адилхан ам бүлтэй байна. Харин ч нэг ам бүлд оногдох хүүхдийн тоо 0,5 хувиар бага байна.

Нийт өрхийн 35,1 хувь нь 1-3 буюу ам бүл цөөнтэй бүлэгт, 31,2 хувь нь 4-6 буюу дундаж ам бүлтэй, 33,7 хувь нь олон ам бүлтэй өрхийн бүлэгт багтаж байгаа нь дэлхийн дундажтай адил байна. Харин өрхийн ам бүлийн тоог хот хөдөөгөөр авч үзвэл дэлхийн дундаж жишгээс бага зэрэг ялгаатай үзүүлэлт гарч байна. Аль ч улс оронд хөдөөгийн өрхөд ам бүл цөөнтэй өрхийн тоо улсын дунджаас илүү, хотод цөөн байдаг бол манай улсад 1-3 ам бүлтэй хувийн жин улсын дунджаас хотод бага /31,8 хувь/, хөдөөд илүү /39 хувь/ байгаа нь хөдөөд амины малыг нэг хүнд бус нэг өрхөд оногдуулан тогтоож өгдөг байснаас эцэг эх нь насанд хүрсэн хүүхдүүдээсээ тусдаа өрхөөр данс бүртгэлтэй байдагтай уялдсан өвөрмөц онцлог юм. Хотод бол байр сууцны хүрэлцээгүйгээс залуу гэр бүл эцэг эхээсээ тусгаарлахгүй нэг өрхөд бүртгэлтэй, нэг сууцанд аж төрдөгтэй холбоотой юм. Мөн хөдөөгийн нэг ам бүлийн тоо, хотынхоос бага байгаа нь үүнтэй адил шалтгаанаар тайлбарлагдана. Нэг өрхөд оногдох ам бүлийн тоо 1990 оныг хүртэл хот хөдөөгүй нэлээд тогтвортой байсан бол 1991 оноос нэг үе цөөрч, одоо дахин нэмэгдэж байгаа нь эдийн засгийн буюу аж амьдралын тогтворгүй байдалтай холбоотой юм. Хүнсний хэд хэдэн нэр төрлийн бүтээгдэхүүнийг өрхөд оногдуулан /архи, цай, шүдэнз, ургамалын тос, ёотон

гэх мэт/ картаар хуваарилаж байхад нэг гэр сууцанд аж төрдөг өрх, 2 өрх болж бүртгэгдэх явдал элбэг байв.

Хүснэгт 1

Өрхийн тоо, хот, хөдөө ам бүлийн тоогоор
/1989 оны тооллогоор/

Ам бүлийн тоо	Бүгд		Хот		Хөдөө	
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Бүх өрх	427834	100,0	235613	100,0	192221	100,0
1	36875	8,6	15017	6,4	21858	11,4
2	49002	11,5	23207	9,8	25795	13,4
3	64124	15,0	36791	15,6	27333	14,2
4	72730	17,0	45366	19,3	27364	14,2
5	60646	14,2	36237	15,4	24409	12,7
6	51004	11,9	29620	12,6	21384	11,1
7	37954	8,9	20970	8,9	16984	8,8
8	25286	5,9	13259	5,6	12027	6,3
9	14867	3,5	7437	3,2	7430	3,9
10+	15346	3,5	7709	3,2	7637	4,0

Энэ нь 1989 оноос хойш улсын хэмжээгээр 30 мянга орчим шинэ гэр бүл бий болсон байхад, нийт өрхийн тоо 100 мянгаар нэмэгдснээс тодорхой харагдана. Харин сүүлийн 2 жилд түлээ нүүрсний үнэ өсөж, сууцны цэвэрлэгээний хөлс зэргийг өрхөөр тооцож авдаг болсон, хүнсний барааг картаар олгохоо больсноос гэр сууцандаа бөөгнөрөн аж төрөх, салангид өрхөө нэгтгэн бүртгүүлэх явдал нэмэгдэв. Жишээ нь 1994 онд улсын хэмжээгээр 512 мянган өрх гэр бүл бүртгэгдсэн бол 1995 оны эхэнд 509 мянга болж цөөрсөн байна. Гэтэл энэ хугацаанд шинээр гэр бүл болсон өрхийн тоо, гэр бүлээ цуцлуулсан өрхийн тооноос 10 дахин олон байсан юм. Аймгууд болон хотоор авч үзсэн ч нэг өрхийн ам бүлийн тоо нэлээд өөрчлөгдсөн байна. Жишээ нь ганцхан жилийн дотор нэг өрхөд оногдох хүний тоо Архангайд 10 хувь, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойр хот, Хэнтий, Хөвсгөл, Сэлэнгэ, Сүхбаатар, Өмнөговь, Дорноговь, Баян-Өлгий аймагт 5-17 хувиар өссөн нь шинээр төрсөн хүүхдийн тоотой нь харьцуулахад 2-10 дахин их үзүүлэлт юм. Гэтэл Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод хүн амын жилийн ердийн цэвэр өсөлт ганцхан хувь орчим байгаа билээ. Дорнод аймагт нэг өрхөд оногдох ам бүлийн тоо 10 хувиар багассаныг тайлбарлах учир шалтгааныг зөвхөн тоо бүртгэлийн будлианаас өөрөөр үзэх үндэслэл алга. Баян-Өлгий аймагт өрхийн тоо 1994 он хүртэлх хугацаанд 1989 оныхоос ихээхэн цөөрсөн нь Казахстанд Монголоос 15 мянган өрх бүр, түр хугацаагаар шилжин суурьшсаны ихэнх нь энэ аймгаас шилжсэнтэй холбоотой. Харин 1995 онд Баян-Өлгий, Ховд аймагт Казахстанас 500 гаруй өрх буцан шилжиж ирсэн нь аймгийн өрхийн тоонд нөлөөлжээ. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод 1995 онд хөдөө аймгуудаас хэдэн мянган өрх шилжин ирж, эдгээр хотуудын шинээр гэр бүл болсон өрхийн тоо, салсан, шилжсэн, нас барсан өрхийн тооноос хэд дахин давсан байтал өрхийн нийт тоо буурсан нь 1-3 өрх нэг байр сууцанд сууж, нэг өрхөөр бүртгэгдэх болсноор л тайлбарлагдана.

1995 оны дунд үеийн мэдээгээр улсын хэмжээгээр 529 мянган өрх байгаагаас 189 мянга нь хөдөөд, 175 мянга нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойр хотод, 165 мянга нь аймгийн сумын төвд болон газар тариалан эрхэлдэг аж ахуйд оршин сууж байна.

1991-1992 онд мал хувьчлах үед хөдөөгийн өрхийн тоо 90 мянга гаруйгаар буюу 2 дахин нэмэгдсэний 2/3 нь сумдын төвөөс мал аж ахуйд шилжин суурьшсан өрх юм. Мөн энэ үед хөдөөгийн өрхийн нийт хүн ам 2 гаруй дахин өсчээ.

Өрхийн тоо, нэг өрхөд ноогдох хүний тоо
аймаг хотоор 1989, 1994, 1995

	Өрхийн тоо			Нэг өрхөд оногдох хүний тоо		
	1989	1994	1995	1984	1994	1995
Архангай	19049	28997	25514	4,4	3,6	4,0
Баян-Өлгий	17386	15655	16804	5,2	4,8	5,1
Баянхонгор	16136	20121	20319	4,6	4,3	4,2
Булган	11661	14856	15145	4,5	4,2	4,1
Говь-Алтай	12453	15220	15300	5,0	4,8	4,8
Дорноговь	12197	11478	10840	4,6	4,3	4,48
Дорнод	15119	17335	18407	4,9	4,9	4,5
Дундговь	10330	11884	11791	4,8	4,4	4,4
Завхан	18355	22404	22479	4,8	4,6	4,6
Өвөрхангай	21714	28160	28315	4,4	3,9	3,9
Өмнөговь	9532	11168	10572	4,5	4,1	4,2
Сүхбаатар	10185	12141	12292	5,0	4,7	4,8
Сэлэнгэ	17651	20744	21492	4,9	4,5	4,7
Төв	21702	24993	24720	4,6	4,4	4,4
Увс	17545	22241	22445	4,8	4,5	4,4
Ховд	15014	18475	18576	5,1	4,8	4,8
Хөвсгөл	23160	28352	28346	4,4	4,1	4,2
Хэнтий	15492	18275	17744	4,5	4,0	4,2
Дархан-Уул	16048	21754	19951	4,9	4,3	4,4
Улаанбаатар	100221	130623	132000	5,2	4,5	4,6
Орхон	9777	14358	13495	4,7	4,4	4,7
Говь-Сүмбэр		2701	2717		4,3	4,4
Дүн	410727	511936	509264	4,8	4,4	4,5

(Гадаадад суугаа өрхийн тоо ороогүй болно.)

Энд хөдөөд шилжсэн өрхийн хүн амын тооноос гадна ТМС, Ерөнхий боловсролын дунд сургуулиас завсардсан, төгссөн, аймаг, сумын төвд ажилгүй болоод хөдөө мал дээрээ гарсан ахмадууд зэрэг 200 мянган хүн хөдөөгийн өрхийн хүн амыг нэмэгдүүлсэн юм. Гэтэл 1995 онд хөдөөгөөс хот, аймаг, сумын төвд шилжсэн өрхийн тоо хэдэн мянгаар, хүн ам 30-45 мянгаар тоологдох болов. Аймаг, сумын төвд үйлдвэр үйлчилгээний газрууд хэвийн ажиллаж эхлэхэд өрх хүн ам нь хөдөөгөөс буцан шилжиж ирэгсэдээр нэлээд нэмэгдэх төлөв одооноос ажиглагдаж эхлэв.

Хөдөөгийн өрхийн доторхи хүн амын тоо нэмэгдэхийн хэрээр мал маллах хүний хөдөлмөрийн бүтээмж хэд дахин буурсан нь хөдөөгийн бараг бүх айл өрх бүрд ажиглагдаж байна. Нэг малчинд оногдох мал 300-400 байснаа /бог/ 80-150 мянга болж буурчээ. Энэ нь ойрын хэдэн жилд сум аймгийн төв болон бусад аймаг хотуудад ажиллах хүчин шаардах үйлдвэрлэл үйлчилгээний газрууд шинээр байгуулагдах, сэргээн ажиллуулах үед хөдөөгөөс олон мянган залуус очиж ажиллах боломжтойг харуулж байна.

Хөдөөгөөс айлууд 1-3 хүүхдээ мал аж ахуй эрхлүүлээд бусад хүүхдээ улс ардын аж ахуйн бусад салбарт ажиллуулах, суралцуулах мэргэжил эзэмшүүлэх хүсэлтэй байдаг. Аль ч аймаг суманд бэлчээр, усны нөөц тодорхой хязгаарын дотор байх тул мал сүргийн тоог одоогийнхоос 2 дахинаас илүүгээр нэмэгдүүлэх боломжгүйг малчид, залуучууд сайн ойлгох болсон нь тэд хүн амын шилжих хөдөлгөөнд хамрагдахад бэлэн байдлыг бүрэлдүүлээд байна. Хөдөөд нэг өрхөд оногдох ам бүлийн дундаж тоо ойрын үед нэмэгдэхгүй, харин ч төрөлт нэлээд их буурсан, залуучууд ажлын байр олдмогц тийш шилжих магадлал илүү байгаагаас хөдөөгийн өрхийн ам бүлийн тоо

бага зэрэг цөөрөх төлөв тодорхой байна. Хот суурингуудад нэг өрхөд оногдох ам бүлийн тоо хөдөөнийхөөс арай илүү байгаа нь орон сууц, түлш, цахилгааны хангамж, үнэ өртөгөөс нэлээд хамааралтай байна. Гэхдээ хотуудад хүн амын ердийн өсөлт жилд 1,5 хувиас хэтрэхгүй байдал нэлээд удаан хадгалагдах, мөн үйлдвэр /дунд хэмжээний/ үйлчилгээ, соёл боловсролын салбар хэвийн ажиллагаагаа сэргээж, үйлдвэрлэл тээвэр хөгжихөд орон сууцны барилгын ажил эрчимжихэд олон өрх байр сууцтай болж, энэ нь хотын нэг өрхөд оногдох ам бүлийн тоог 30 орчим хувиар цөөрүүлэх /ойрын 10–15 жилд/ төлөв харагдаж байна.

Манай улсын нэг өрхөд оногдох ам бүлийн тоо дэлхийн дунджаас хэтрэхгүй байгаа болон цаашид харин ч багасах хандлагатайг бодитойгоор тооцож, "Монгол айл олон ам бүлтэй" гэсэн үндэслэл муутай ойлголтоос ангид төлөвлөж тооцоолж хэвших нь улс орны нийгэм эдийн засгийн төлөвлөлт тооцооллын үндэслэлийг нэмэгдүүлнэ.

Монголын өрх гэр бүлийн бүтцэд гарч байгаа нэг сөрөг өөрчлөлт бол хагас өнчин хүүхэд бүхий бүрэн бус гэр бүлийн тоо сүүлийн хэдэн жилд хурдан нэмэгдэж байгаа явдал юм. Бүтэн өнчин, хагас өнчин хүүхдийн хувийн жин багатай улс орны тоонд Монгол саяхан болтол багтаж байсан бол 1990 оноос хойш энэ богино хугацаанд хагас өнчин хүүхэдтэй гэр бүлийн тоо энх цагт тохиолддоггүй хурдтайгаар буюу 81 хувиар, жилд дунджаар 16 хувиар нэмэгдэж, хагас өнчин хүүхдийн тоо 57,2 мянга хүрэв. Хагас өнчин хүүхдийн тоо Архангайд 53 хувь, Баян-Өлгийд 47 хувь, Баянхонгорт 57 хувь, Дорнодод 69 хувь, Дундговьд 72 хувь, Завханд 39 хувь, Өвөрхангайд 66 хувь, Сүхбаатарт 30 хувь, Төв аймагт 38 хувь, Увсад 51 хувь, Ховдод 78 хувь, Хөвсгөлд 48 хувь, Хэнтийд 28 хувь, Дарханд 10 хувь, Улаанбаатарт 39,9 хувь буюу 4 дахин, Эрдэнэтэд 2,5 дахин нэмэгджээ. Харин хэв журам, гэмт хэргийн зөрчил бага, эрүүл мэндийн салбарын ажил харьцангуй хэвийн байгаа гэж болох Булганд 29 хувь, Өмнөговьд 13 хувь, Сэлэнгэд 10 хувиар цөөрчээ.

Хагас өнчин хүүхдийн тоо 1995 онд 60 мянга хүрсэн нь Булган аймгийн хүн амын тоотой, Архангай, Баян-Өлгий, Завхан, Өвөрхангай, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн хагас өнчин хүүхдийн тоо 2–3,4 мянга хүрсэн нь дундаж тооны хүн амтай сумдын хүн амын тоонд хүрчээ. Нийслэл Улаанбаатарын хагас өнчин хүүхдийн тоо 22 мянга хүрч, Говь-Сүмбэр аймгийн хүн амын тооноос 2 дахин давжээ. Үүнээс 0–6 насны хагас өнчин хүүхдийн тоо 3,7 дахин нэмэгдэж 7,2 мянга, 7–15 насных 4,1 дахин нэмэгдэж 14,2 мянга хүрчээ.

Бүтэн өнчин хүүхдийн тоо Баянхонгорт 2,4 дахин, Сүхбаатар аймагт 50 хувь, Төв аймагт 44 хувь, Увсад 47 хувь, Хөвсгөлд 49 хувь нэмэгдсэн байна. Энэ бүхний цаана 20 мянга шахам бүрэн бус гэр бүл /айл өрх/ байгаа бөгөөд өсөлтийнх нь хурдац ийм аймшигтай их байгаа нь манай улсад эрүүлийг хамгаалах, эрүүгийн гэмт хэргийг бууруулах, хөдөлмөр хамгааллыг сайжруулах асуудал дэндүү доод шатанд орсныг харуулсан үзүүлэлт болж байна. Дайн болоогүй, газар хөдлөлт, хөнөөлт тахал усны их үер болоогүй үед хагас өнчрөл үзсэн гэр бүл, өнчирсэн хүүхдийн тоо ингэж хурдан өсдөг тохиолдол дэлхийд нэн ховор юм.

Энэхүү зүй бус үзэгдлийг сааруулах, улмаар хамгийн бага үзүүлэлтэнд хүргэхийн тулд эмзэг давхаргын хүнсний хангамжийг сайжруулах, ажилгүйдлийг эрс багасгах, хүнсний үйлдвэрлэлийн аливаа хэлбэрийг тууштай дэмжих, олон хүүхэдтэй эхчүүдийн тэтгэвэрийг нэмэгдүүлэх /5-аас доошгүй/, хүн амын өвчлөлтийг мэдэгдэхүйц бууруулах, эрүүлийг хамгаалах салбарын ажлыг бүх шатанд нь сайжруулах, нийгмийн хэв журмыг сахиулах явдлыг тууштай чангатгах, хөдөлмөрийн нөхцлийг шаардлагын хэмжээнд хүртэл сайжруулж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажилгааны горим журмыг үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн аль ч салбарт дээд түвшинд хүргэх талаар тууштай арга хэмжээнүүд боловсруулж, амьдралд ямар ч ухралтгүй хэрэгжүүлэх нь үндэсний эрх ашгийн шаардлага болж байна.

Монгол дахь өрөөсгөл гэр бүлийн нэг хэлбэр нь гэр бүл бололгүйгээр хүүхэд гаргасан эмэгтэйчүүдийн ам бүл юм. 1980-аад оноос хойш жил тутмын дундаж үзүүлэлтээр гэр бүл бололгүйгээр хүүхэд төрүүлсэн эхчүүд тухайн жилд төрсөн эмэгтэйчүүдийн 15–13,5 хувийг эзлэж, хушийн жин нь тууштай буурахгүй байгаа явдал

юм. Энэ нь Франц зэрэг орнуудынхтай харьцуулахад бага үзүүлэлт боловч, цаашид мэдэгдэхүйц бууруулж болох үзүүлэлт юм. Гэр бүл бололгүйгээр хүүхэд төрүүлэх явдлыг 1950–1960–аад онд хоёр дахин бууруулсан боловч сүүлийн 100–аад жилд шарын шашны уршгаар гэрлэлт багасч, эмэгтэйчүүд нөхөргүй ч гэсэн "гараас нь хөтлөх, үнэрлэх үртэй болох" гэсэн сэтгэлгээгээр хүүхэд төрүүлэхээс цааргалддаггүй байсан уламжлалын үр дагавар арилаагүйн шинж болж байгаа юм. Гэрлэлгүйгээр хүүхэд төрүүлсэн эхчүүдийн нэлээд хэсэг нь эцэг, эхтэйгээ хамт нэг гэрт амьдардаг тул хүүхэдтэй айлын тоо мэдээлэл гаргахад заримдаа бэрхшээл учруулдаг хэвээр байна.

Хүснэгт 3

Эмэгтэйчүүд толгойлсон өрхийн тоо, хүүхдийн тоо, аймаг хотоор /1994 он/

	1990				1994			
	Бүх өрх	Хүүхдийн тоогоор			Бүх өрх	Хүүхдийн тоогоор		
		3–аас цөөн	3–5	6 ба дээш		3–аас цөөн	3–5	6 ба дээш
ДҮН	19789	4094	11687	4008	40819	15818	14606	10395
Архангай	633	50	418	165	1875	947	568	360
Баян-Өлгий	82	–	52	30	906	319	316	271
Баянхонгор	1056	291	588	177	2038	820	701	517
Булган	608	121	388	99	992	345	390	257
Говь-Алтай	1098	79	681	338	1554	595	492	467
Дорноговь	607	143	383	81	898	374	302	222
Дорнод	701	422	183	96	772	295	229	248
Дундговь	601	23	502	76	923	349	359	215
Завхан	1456	266	849	341	1825	760	532	533
Өвөрхангай	1144	217	727	200	1535	733	444	358
Өмнөговь	772	216	416	140	1367	570	502	295
Сүхбаатар	509	113	307	89	1042	364	319	359
Сэлэнгэ	1085	283	563	239	1475	472	581	422
Төв	876	207	549	120	1861	787	620	454
Увс	730	78	414	238	1998	908	614	476
Ховд	821	10	457	354	1498	507	488	503
Хөвсгөл	1600	346	842	412	3280	1352	1200	728
Хэнтий	631	132	377	122	1305	480	537	288
Дархан	933	401	476	56	1523	621	664	238
Улаанбаатар	3246	696	2169	381	11362	3798	4492	3072
Эрдэнэт	600	–	346	254	600	294	192	108
Чойр	–	–	–	–	190	128	58	4

Таван жилийн хугацаанд эмэгтэйчүүд толгойлсон өрхийн тоо 2 гаруй дахин, үүнээс Архангай, Увсад 3, Баян-Өлгийд 11, Баянхонгорт 2, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Сэлэнгэд 0,5, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Дарханд 2, Улаанбаатарт 3,5 дахин нэмэгджээ.

Бүрэн бус гэр бүлийн хамгийн олон тоотой нь бэлэвсэрсэн гэр бүл юм. 1957 оноос хойш жил бүрийн нас барсан хүний тоонд эрэгтэйчүүдийн хувийн жин тогтмол нэмэгдсээр 1989 оноос бүр ч хурдан нэмэгдэж, 1994 онд нас барагчдын 56,2 хувийг эрэгтэйчүүд, 43,8 хувийг эмэгтэйчүүд эзлэх болов. 1994 онд улсын хэмжээгээр 16546 хүн нас барсны 9294 нь эрэгтэй, 7252 нь эмэгтэйчүүд байв. Нас барсан хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин Булганд 56,5 хувь, Дорнодод 57,5 хувь, Сэлэнгэд 63,1 хувь, Төв аймагт 59,1 хувь, Хэнтийд 56,8 хувь, Дарханд 58,3 хувь, Улаанбаатарт 57,6 хувь, Эрдэнэтэд 58,2 хувь болж, бэлэвсэрсэн

эмэгтэйчүүдийн толгойлсон өрхийн тоо улам нэмэгджээ. Нас барсан дээд боловсролтой эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 3,85 дахин, тусгай дунд боловсролтой нь 3 дахин, бүрэн дунд боловсролтой нь 2,5 дахин олон байгаа бөгөөд энэ нь бэлэвсэн эмэгтэйчүүд толгойлсон гэр бүлийн тоог нэмэгдүүлж байдгийг дахин баталж байна.

Бүрэн бус гэр бүл бий бологсдын нэг хэсэг болох гэмт хэрэг үйлдэгсэдийн тоо 1991 оныхоос 1994 онд 10584 байснаа 16272 болж, 60-аад хувиар өсөв. Тэдний 96 хувь нь эрэгтэйчүүд учраас тодорхой хугацаанд эмэгтэйчүүд толгойлсон бүрэн бус гэр бүлийн тоо мөн л төдий тоогоор өсдөг байна. Гэмт хэрэг үйлдээд урт богино хугацаагаар шийтгүүлэгчид жилдээ 6-8 мянгад эргэлдэж /97 хувь нь эрэгтэйчүүд/, хэдэн сараас хэдэн жилээр бүрэн бус гэр бүлийн тоог нэмдэг. Шийтгүүлж бүрэн бус гэр бүл үүсгэгчдийн тоогоор Улаанбаатар /4 мянга/, Дархан хот, Сэлэнгэ, Өвөрхангай, Төв, Хэнтий, Дорнод, Дорноговь, Баянхонгор, Архангай аймгууд /400-700 өрх/ илүү байна.

Бүрэн бус гэр бүлийн тоо өсч байгааг зогсоохын тул улс орны нийгэм-эдийн засаг, улс төрийн амьдралыг аль болох ойрын хугацаанд тогтворжуулах зорилт тавих шаардлагатай юм. Бүрэн бус гэр бүл олшрох тусам, эргээд улс орны амьдралд муугаар нөлөөлж, нийгэм-эдийн засгийн тогтворжилтыг саатуулдаг учир бүрэн бус гэр бүл үүсэхээс аль болохоор сэргийлэх нь зүйтэй юм.

Өрхийн бүтцэд гарч буй нэг том өөрчлөлт нь ядуу өрх нэмэгдэж байгаа явдал юм. Ядуу өрхийн гишүүдийн нэлээд хэсэг нь тахир дутуу хүмүүс юм. Тахир дутуу хүмүүсийн тоо жилд дунджаар 28 мянга орчимд эргэлдэж байдгаас 6,7 мянга орчим нь төрөлхийн, 20 мянга гаруй өвчлөлт, үйлдвэрлэлийн ба ахуй, зам тээврийн осол байгалийн гамшигт нэрвэгдэгсэд байдаг. Тахир дутуу хүмүүсийн ажиллаж байсан газар нь сул зогссон, хувьчлагдсан, дампуурсан шалтгаанаар тэдэнд тус дэмжлэг үзүүлэхгүй болсон нь ядуурлыг нь улам лавшруулав. Тахир дутуу хүмүүсийг хөдөлмөр эрхлүүлэх нөхцөл бүрэлдүүлэх тусгай хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр тахир дутуу болсон хүмүүсийг төр засгаас тэтгэлэг тусламж үзүүлэх, тэдний ажиллаж байсан байгууллага, үйлдвэр, пүүс, компани, хоршоо нь сар бүр тэтгэлэг төлбөр /нөхөн/ тогтмол олгох, байр сууцаар эхний ээлжинд хангах явдлыг хуульчлан хэвшүүлвэл, хөдөлмөр хамгаалал эрс сайжрах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр хөдөлмөрийн чадвараа алдах явдлыг хамтад нь мэдэгдэхүйц багасгах бололцоотой болно.

Ядуурлыг нэмэгдүүлэхэд ажилгүйдэл тэргүүлэх үүрэгтэй байгаа бөгөөд улс ардын аж ахуйн бүх салбарыг хамарсан ажилгүйдэл нь ядуурлыг гүнзгийрүүлсээр байна. Аль ч улсад ажилгүйдэлд хамгийн бага өртдөг хүний их эмч нарын хувьд гэхэд 1994 онд хүний их эмчийн тоо 5,4 хувь, эмэгтэйчүүдийн эмч нар 8,3 хувь, хүүхдийн эмч нар бүр 43 хувиар цөөрч нэлээд хэсэг нь ажил мэргэжлээ сольж, багагүй хэсэг нь ажилгүйджээ. 1990 онд 441 ясли /хүүхэд саатуулах газар/ ажиллаж байснаас 1994 онд 370 нь хаагдаж хэдэн мянган хүн ажилгүйчүүдийн эгнээнд шилжжээ. Хүүхдийн эмчийн 530 хэсгээс 404 нь хаагдаж, мянгаар тоологдох хүн ажилгүйджээ. Эхчүүдэд зөвөлгөө өгөх 101 газраас 17 нь бас хаагджээ.

Ерөнхий боловсролын багш нарын тоо 1,6 мянгаар цөөрсөн төдийгүй төрөлт багасаж, 1990 оноос эхлэн тухайн жилд төрсөн хүүхдийн тоо өмнөх жилийнхээс буурч байгаагийн нөлөөгөөр 1996-1997 оны хичээлийн жилээс эхлэн 1-р ангид шинээр элсэх хүүхдийн тоо жил бүр 5-35 мянгаар цөөрөх тул жил бүр 100-1000 багш нар ажилгүйдэх бөгөөд энэ нь 8-10 жил үргэлжлэх төлөвтэй байна.

Өрхийн судалгаанд төрөх насны эмэгтэйчүүдийн төрүүлсэн хүүхдийн тооны судалгаа нэг үндсэн үзүүлэлт болдог.

Олон улсын эрдэмтдийн хүлээн зөвшөөрсөн дундаж тооцооллоор нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 2,17-2,24 байгаад нялхсын нас баралт мянган хүүхдээс 10-аас хэтрэхгүй байвал тэр улсын хүн ам байгалийн жамын

өсөлтийг хангана гэж үздэг. Одоо дэлхийд нэг эмэгтэйд дунджаар 3,4-3,6 хүүхэд оногдож байгаа билээ.

Хүснэгт 4

15 ба түүнээс дээш насны эмэгтэйд ноогдох хүүхдийн тоо, эхийн насаар 1989 оны тооллогоор

Эмэгтэй чүүдийн насны бүлэг	Эмэгтэй чүүд Бүгд	Нэг эмэгтэйд ноогдох хүүхдийн тоо	Хүүхэд төрүүлээгүй эмэгтэйчүүд	Хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд	төрүүлсэн нийт хүүхдийн тоо	хүүхэд төрүүлсэн нэг эмэгтэйд ноогдох хүүхдийн тоо
Бүгд	599725	3.0	195474	404251	1817926	4.5
15-19	109071	0.0	105171	3900	4378	1.1
20-24	98547	0.8	48009	50538	81085	1.6
25-29	90796	2.3	12109	78687	212539	2.7
30-34	68036	3.8	4413	63622	255275	4.0
35-39	46001	4.9	2404	43597	223651	5.1
40-44	34626	5.9	1770	32856	203934	6.2
45-49	32883	6.6	2085	30798	217442	7.1
50-54	27273	6.6	2256	25017	179007	7.1
55-59	25651	6.1	2818	22833	157000	6.9
60-64	18637	5.1	2928	15709	94633	6.0
65-70	17114	4.5	3282	13832	76469	5.5
70+	31091	3.6	8229	22862	112513	4.9

Манай улсад 1989 оны байдлаар төрөх насны нэг эмэгтэйд оногдох хүүхдийн тоо 3,0 байгаа нь дэлхийн дунджаас бага байна. Өөр нэг анхаарууштай зүйл нь дэлхийн дунджаар хүүхэд төрүүлэх насны эмэгтэйчүүдийн 75 хувь нь хүүхэд төрүүлсэн байдаг. Гэтэл Монгол улсын төрөх насны эмэгтэйчүүдийн дөнгөж 67 хувь нь хүүхэд төрүүлсэн /1989/ байв. Үүнээс үзвэл манай зарим хүмүүсийн монгол эмэгтэйчүүд олон хүүхэд төрүүлдэг гэж ярьж бичдэг нь судалгаагүй өнгөц дүйвээний ойлголт болох нь тод харгдаж байна. Харин энд барууны орнуудад нэг эмэгтэйд оногдох хүүхдийн дундаж тоо дэлхийн дунджаас 50 хувь бага байдаг боловч хүүхэд төрүүлсэн /гол төлөв 1-2 хүүхэд төрүүлдэг/ эмэгтэйчүүдийн хувийн жин төрөх насны эмэгтэйчүүдийн 3/4 –өөс багагүй байдаг бөгөөд үргүйдэл бараг байдаггүй. Манайд төрөх насны эмэгтэйчүүдийн 5-аас илүү хувь нь үргүйдлээр өвчилсөн байдгийг доцент Ж.Раднаабазар тогтоожээ. Энэ нь төрөх насны эмэгтэйчүүдийн тоог бодит байдалд нэлээд бууруулдаг.

Монгол эмэгтэйчүүд эрт төрдөг ангилалд багтахгүй байгааг /1989 онд/ 19-өөс доош насны эмэгтэйчүүдийн дөнгөж 3,8 хувь, 20-24 насны эмэгтэйчүүдийн 51 хувь нь хүүхэд төрүүлсэн бөгөөд 16-24 насны эмэгтэйчүүдэд дунджаар нэг хүүхэд оногдож байгаа баримт нотолно. 25-30 хүртэлх насны эмэгтэйчүүдэд дунджаар 2,3 хүүхэд оногддог бөгөөд дэлхийн дунджаас /3,3/ нэлээд бага байна.

Хүүхэд төрүүлсэн монгол эмэгтэйчүүдийн /1989 он / 38,9 хувь нь цөөн хүүхэд төрүүлсэн /1-2 хүүхэд/, 25,8 хувь нь 3-4 хүүхэд, 35,3 хувь нь 5 ба түүнээс олон хүүхэд төрүүлсэн эхчүүд байв. 1995 оны байдлаар цөөн хүүхэд төрүүлсэн эхчүүдийн хувийн жин 41,5 хувь, 3-4 хүүхэд төрүүлсэн эхчүүдийнх 26,5 хувь, 5 ба түүнээс олон хүүхэд төрүүлсэн эхчүүдийн хувийн жин 32 хувь болж өөрчлөгдсөн байлаа. Эдгээр тоо баримтаас үзэхэд монгол эмэгтэйчүүдийг олон хүүхэд төрүүлдэг ангилалд хамааруулах үндэслэл илүүтэй байна. Нөгөө талаар 45-аас дээш насандаа хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд, жил тутмын хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 0,3 орчим хувь байгаа нь дэлхийд хамгийн бага үзүүлэлт юм. Ийм

болохоор монгол эмэгтэйчүүдийг эрт буюу орой хүүхэд төрүүлдэг гэж ярьж бичиж байгаа нь бас л нотлогдохгүй байна. Энэ бүгд нь монгол эмэгтэйчүүд олон хүүхэдтэй гэж дэлхий дахинд зарлах нь бас л үндэслэл муутай болохыг давхар нотлож байна.

Монгол оронд хүүхэдтэй айл өрх бүх гэр бүлийн 70 хувийг эзэлж байна. Хүүхэдтэй өрхийн 51,2 хувь нь цөөн /1-2 хүүхэдтэй/, 33 хувь нь 3-4 хүүхэдтэй. Ердөө 15,8 хувь олон хүүхэдтэй /5 ба дээш хүүхэдтэй/ гэр бүл байна. 10-аас олон хүүхэдтэй айл 1000 өрх тутамд ганц оногдож байна. Энэ нь монгол айл олон хүүхэдтэй гэдэг ойлголт ихээхэн өрөөсгөл гэдгийг бас дахин нотлож байна.

Хүүхэдтэй айлуудын хот хөдөөгийн ангилалаар авч үзсэн харьцуулалтанд зарим ялгаа ажиглагддаг. Хотод хүүхэдтэй өрхийн 55,3 хувь, хөдөөд 45,7 хувь нь цөөн хүүхэдтэй /1-2 хүүхэдтэй/, хотод 31,4 хувь, хөдөөд 33,9 хувь нь 3-4 хүүхэдтэй, хотод 13,7 хувь, хөдөөд 20,4 хувь нь 5 ба түүнээс олон хүүхэдтэй байна. Хөдөөгийн нэг гэр бүлд оногдох хүүхдийн тоо хотынхоос арай олон, цөөн хүүхэдтэй айлын эзлэх хувийн жин хотынхоос бага байна.

Хүүхэдтэй гэр бүлийн 42,3 хувь хөдөөд оршин суудаг боловч цөөн хүүхэдтэй гэр бүлийн 37,8 хувь, 3-4 хүүхэдтэй гэр бүлийн 43,5 хувь, олон хүүхэдтэй гэр бүлийн 55,1 хувь хөдөөд оршин сууж байна. Хотын нэг гэр бүлд оногдох хүүхдийн тоо, нэг эхийн төрүүлсэн хүүхэд хөдөөнийхөөс цөөн байгаа нь хотын эмэгтэйчүүдийн дотор дээд, тусгай дунд боловсролтой эхчүүдийн хувийн жин өндөр байдагтай холбоотой юм. 1989 оноос үр хөндөлтийг чөлөөтэй болгосноос хойш, улмаар 1990 оноос гэр бүл төлөвлөлтийн бодлого сурталгааг эрчимтэй явуулах болсны улмаас хотын эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэх тоо 2-3 дахин багасаж, нөгөө талаар олон хүүхэдтэй айлуудын хүүхдийн нэлээд хэсэг насанд хүрэв.

Хүснэгт. 5

Өрхийн тоо хот, хөдөө, хүүхдийн тоогоор
/1989 оны тооллогоор/

Хүүхдийн тоо	Бүгд		Хот		Хөдөө	
	тоо	дунд эзлэх хувь	тоо	дунд эзлэх хувь	тоо	дунд эзлэх хувь
Бүх өрх	323070	100,0	186146	100,0	136924	100,0
1	81873	25,4	49307	26,5	32566	23,8
2	83449	25,8	53527	28,8	29922	21,9
3	61377	19,0	35826	19,2	25551	18,7
4	45298	14,0	24531	13,2	20767	15,2
5	28102	8,7	13501	7,2	14601	10,7
6	14291	4,4	6142	3,3	8149	5,9
7	5880	1,8	2263	1,2	3617	2,6
8	2006	0,6	739	0,4	1267	0,9
9+	794	0,3	310	0,2	484	0,3

Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, Сэлэнгэ, Төв аймгийн олон хүүхэдтэй айлуудын насанд хүрч байгаа хүүхдийн тооноос, шинээр төрж буй хүүхдийн тоо олон дахин цөөн байгаагаас эдгээр аймаг хотын хүүхэдтэй айлд оногдох хүүхдийн тоо мэдэгдэхүйц цөөрчээ. Хөдөөд бол шинээр төрж байгаа, насанд хүрч байгаа хүүхдийн тоо бараг тэнцүү байгаа тул олон цөөн хүүхэдтэй гэр бүлийн эзлэх хувийн жин тогтонги байгаа юм.

Өрх гэр бүлийн тогтолцооны үндсэн төрхийг тодорхойлохын тулд гэрлэлтийн нийтлэг зүй тогтол, өвөрмөц онцлогыг тодруулах шаардлагатай.

Сүүлчийн хүн амын тооллогын мэдээгээр гэр бүл болох насны 532,1 мянган эмэгтэйчүүд байснаас 348,1 мянга нь гэр бүл болсон, 59,6 мянга нь бэлэвсэрсэн, 10,9 мянга нь гэр бүлээ цуцалсан, 113,5 мянга нь огт гэрлээгүй байв.

Хүснэгт 6

Эмэгтэйчүүдийн гэрлэлтийн байдал, насны бүлгээр
/1989 оны тооллогоор/

Насны бүлэг	Бүгд	Гэрлэлтийн байдал			
		Гэрлэсэн	бэлбэсэн	цуцалсан	огт гэрлээгүй
Бүгд	532075	348134	59587	10874	113480
16	53	53			
17	232	232			
18	21349	920	5	19	20405
19	19787	2453	16	47	17271
16-19	41421	3658	21	66	37676
20-24	98547	50089	284	1081	47093
25-29	90796	73774	732	2518	13772
30-34	68035	59279	1155	2451	5120
35-39	46001	40665	1514	1567	2255
40-44	34626	29918	2301	1024	1383
45-49	32883	26768	3912	870	1333
50-54	27273	20577	5078	551	1067
55-59	25651	17194	7329	290	838
60-64	18637	10319	7527	164	627
65-69	17114	7588	8720	116	690
70+	31091	8305	21014	146	1636

Эндээс ажиглахад гэрлэх насны эмэгтэйчүүдийн 65,7 хувь нь гэрлэсэн, 11,2 хувь нь бэлбэсэрсэн /1990 оноос хойш энэ үзүүлэлт нэлээд нэмэгдсэн/, 2 хувь нь гэрлэлтээ цуцлуулсан, 21,3 хувь нь огт гэрлээгүй байлаа. Үүнээс огт гэрлээгүй эмэгтэйчүүдийн хувийн жин дэлхийн дунджаас илүү байв. Харин гэрлэлтээ цуцлуулсан эмэгтэйчүүдийн хувийн жин дэлхийн дунджаас бага байна. 20-оос доош насны гэрлэх насны эмэгтэйчүүдийн 91 хувь нь гэрлээгүй байгаа нь манай эмэгтэйчүүд эрт гэрлэдэггүйг харуулж байна. Мөн 20-24 насны эмэгтэйчүүдийн дөнгөж 50,8 хувь нь гэрлэсэн байв.

Хүснэгтээс (Хүснэгт 7) дүгнэлт хийхэд Монгол оронд гэрлэлтийн дундаж нас зохистой хэмжээнд байгаа бөгөөд эрт, орой гэрлэлттэй орнуудын ангилалд орохооргүй байна. Эхнэр, нөхөр болох хүмүүсийн насны зөрөө улсын дунджаар 4,58 байгаа нь дэлхийн жишигтэй ойролцоо бөгөөд гэрлэлтийн дундаж насны нутаг дэвсгэрийн ялгаа төдий л ажиглагдсангүй. Хөдөөд гэрлэлтийн дундаж нас хотынхоос арай бага буюу 0.33 насаар бага байгаа нь хот хөдөөгийн залуучуудын боловсрол бараг адил түвшинд буй нөлөө юм.

Харин хөдөөд явуулсан хээрийн судалгааны урьдчилсан дүнгээс харахад 1989 оноос хөдөөгийн сургуулиас олон мянган хөвгүүд, охид мал аж ахуйд гарсны нөлөөгөөр гэрлэх дундаж нас 0,5-1 насаар залуужих төлөв харагдаж байв. Мөн мэргэжил, дээд тусгай боловсрол эзэмшихэд хөдөөгийн залуучуудад нэлээд бэрхшээлтэй болсноос эртхэн айл гэр болж, амьдралаа төвхнүүлэх нь дээр гэсэн бодол яриа нэлээд газар авах шинжтэй байна. Гэхдээ охидыг хэт залууд нь гэрлүүлэх бодол санаа төдий л газар аваагүй бололтой.

1988 оноос өмнө залуусаас судалгаа авахад санаа сэтгэл нийлсэн, бие биеэ танин мэдсэн бол хаанахын ч хүнтэй гэр бүл болно гэсэн санал давамгайлж байсан бол сүүлийн 2 жилд Ховд, Увс, Хөвсгөл, Завхан, Дундговь, Архангай, Булганд

залуучуудаас асуулга авахад нутгаасаа таних мэдэх айлынхаа залуустай гэр бүл болно гэсэн санал давамгайлж байгаа нь нийгмийн дэг журам суларсны нөлөө бололтой.

Хүснэгт 7

Гэрлэлтийн дундаж нас, хүйс, аймаг, хотоор. 1989

	Бүгд		Хот		Хөдөө	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
Дүн	24,24	19,65	24,37	20,22	24,04	18,89
Архангай	23,70	19,65	24,20	20,29	23,55	18,74
Баян-Өлгий	23,27	19,08	23,30	18,54	23,28	19,28
Баянхонгор	23,27	19,72	25,33	21,51	24,33	19,02
Булган	24,61	19,90	25,19	20,84	24,24	19,51
Говь-Алтай	24,51	18,83	25,68	18,37	24,95	18,92
Дорноговь	25,18	18,06	23,61	18,53	24,34	17,49
Дорнод	23,86	18,65	23,65	19,74	24,15	17,3
Дундговь	23,79	20,05	23,76	19,96	24,22	20,05
Завхан	24,07	19,09	24,41	18,68	24,37	19,23
Өвөрхангай	24,41	19,48	24,50	19,32	24,13	19,58
Өмнөговь	24,40	19,93	24,03	18,37	24,61	20,88
Сүхбаатар	24,21	20,13	24,40	19,17	24,24	18,77
Сэлэнгэ	23,63	19,46	23,42	20,24	23,85	18,45
Төв	23,93	19,43	23,75	20,61	23,98	19,07
Увс	23,87	18,68	24,32	17,85	23,71	18,8
Ховд	23,68	19,41	23,62	20,35	23,69	18,97
Хөвсгөл	24,17	18,82	24,46	20,42	24,04	18,24
Хэнтий	23,31	18,00	23,18	18,20	23,52	18,13
Дархан	23,76	19,11	23,76	19,11	—	—
Улаанбаатар	24,84	21,05	24,84	21,05	—	—
Эрдэнэт	23,58	19,05	23,58	19,05	—	—

Гэрлэлтийн ерөнхий коэффициент тогтмол бус, ойр ойрхон жилд ч хэлбэлзэл ихтэй байгаа нь бүртгэл мэдээллийн шинэчлэлтийн арга хэмжээтэй холбоотой болов уу? Жишээ нь: 1977, 1978, 1980, 1984 онд паспорт, гэрчилгээг шинэчилсэн, хүүхдийн эцэг тогтоох ажлыг эмхлэн цэгцэлсэн, 1988 онд иргэний бүртгэл регистрт шинэчлэлт хийсэн, 1991 онд өмч хувьчлалт, ялангуяа хөдөөд мал хувьчлалт болсонтой холбогдуулж, гэрлэлтийг баталгаажуулсан арга хэмжээнүүд авсантай холбоотой юм. Харин 1993–1994 онд гэрлэлт буурсан нь эдийн засгийн хямралын уршиг дагавар юм. Гэр бүл цуцлалтын коэффициент харьцангуй жигдэвтэр байгаа бөгөөд 1988 онд эрс нэмэгдсэн нь регистрийн бүртгэлийн шинэчлэлттэй холбоотой юм.

Гэрлэлт, гэр бүл цуцлалтын коэффициентийг харьцуулан жишихэд дунджаар 20/1 –ийн харьцаа, өөрөөр хэлбэл 20 гэрлэлт тутамд 1 гэр бүл цуцлалт оногдож буй нь Монгол улсад гэр бүлийн батжилт дэлхийн дунджаас нэлээд дээгүүр байгааг харуулж байна. Монголд өрөөсгөл гэр бүл нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах нь анхдагч шаардлага болж байна.

Дээр авч үзсэн дүн шинжилгээ хийсэн олон үзүүлэлт харьцуулалтын хүн ам зүйн үзүүлэлтүүдийн 70–80 : нь дэлхийн дундаж үзүүлэлтүүдийн сайн үнэлгээнд хамрах бүлэглэлд багтаж байгаа учраас "Монгод гэрлэлт эртдэж байна, олон хүүхэд төрүүлж байна, гэр бүл төлөвлөлт зайлшгүй шаардлага боллоо" гэх зэргээр сандрах үндэслэл байхгүй байгааг харуулж байна.

Гэрлэлт, гэр бүл цуцлалт, тэдгээрийн коэффициент.

Он	Гэрлэсэн	Гэрлэлтийн ерөнхий коэффициент	цуцалсан	цуцлалтын ерөнхий коэффициент
1970	3890	3,11	170	0,14
1971	5308	4,18	179	0,14
1972	6214	4,68	128	0,09
1973	6667	4,89	120	0,09
1974	7725	5,62	189	0,14
1975	9538	6,64	153	0,11
1976	7004	4,95	160	0,11
1977	18842	12,47	288	0,19
1978	15543	10,04	267	0,17
1979	12601	7,91	335	0,21
1980	16817	10,28	498	0,30
1981	15505	9,46	560	0,34
1982	12714	7,37	488	0,28
1983	14353	8,11	573	0,32
1984	15811	8,72	643	0,35
1985	17065	9,19	758	0,41
1986	17031	8,96	983	0,52
1987	19086	9,81	1031	0,53
1988	21857	10,98	1658	0,83
1989	15596	7,62	1014	0,50
1990	17968	8,54	1127	0,54
1991	21940	10,18	1095	0,51
1992	18232	8,29	984	0,45
1993	13807	6,16	768	0,34
1994	15922	7,05	731	0,32

Харин гэрлээгүй хүмүүсийн хувийн жинг аажмаар багасгах, өрөөсгөл гэр бүлийн тоог хурдан нэмэгдүүлж буй ажилгүйдэл, ядууралтай тууштай тэмцэх, үргүйдлийг эмчлэх, эрүүл эхээс эрүүл хүүхэд төрүүлэх, өмнө олсон эрүүл мэнд хүн ам зүйн ололтыг хадгалахад голлон анхаарсан хүн ам зүйн бодлого явуулах, чөлөөт үр хөндөлтийг хязгаарлах нь энэ тэргүүний зорилт болж байна. Хамгийн чухал нь Монгол улсын хүн амын бодлогын хуультай болох явдал юм.